

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022.12.05

ЗД ҮА Х-т тус гаг дс ан зор ил т	Дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэ гжих хуга цаа	Үндсэн хэрэгжү үлэх байгуул лага	Эх үүс вэр	Нийт хөрө нгий н хэмж ээ (сая төгр өг)	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хэрэгжилт	Хэрэ гжил тийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсө в (сая. төг)	Төсви йн гүйцэт гэл (сая.т өг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	4.1.4.1	“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах.		ННДГ			Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл 100 хувийн гүйцэтгэлтэй байна.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.			Тус газрын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт болон шилэн дансны цахим хуудсанд мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулж буй байдалд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын дагуу нийслэлийн хэмжээнд 2022 оны сарын байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах 2199 мэдээ тайлангаас 2137 мэдээг хугацаанд нь, 62 мэдээг хугацаа хоцроож байршуулсан ба 97,1 хувьтай байна.	
2	4.2.2.1	Төрийн албан хаагчийг авлига, хээл хахууль авах, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үндэсний		ННДГ			Авлигын эсрэг хуулийн дагуу төлөвлөгөө боловсруулан батлуулж төлөвлөгөөнд	Авилга хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтыг 40 хувиар бууруулсан байна.			Нийгмийн даатгалын хууль тогтоомж хэрэгжүүлэхэд иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх зорилгоор ямар үйлчилгээ авахад ямар материал бүрдүүлэх, хаана хандах зэрэг асуудлын талаар цахим хуудсаар мэдээлэх, нийтэд хамааралтай журмыг цахим хуудсанд байрлуулах, сурталчлах, таниулах арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Мөн Төрийн албыг авлигаас ангид байлгах, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг	

		хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, түүнд хяналт тавьж ажиллах.					тусгагдсан 5 ажил биелсэн байна. Авилгын гэмт хэрэгт холбогдоог үй болно.			<p>мэдээллийг өргөн хүрээгээр нэмэгдүүлэх зорилгоор тус газрын албан хаагчид Авлигатай тэмцэх газрын “Авлигатай тэмцэх газар” АТГ-Олон нийтийн төв” фейсбүүк хуудсанд нэгдлээ. Авлигын эсрэг хуулийн дагуу жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор хуулийн үйлчлэлд хамрагдах албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогоо мэдүүлэх үүрэгтэй бөгөөд тус газрын 99 мэдүүлэг гаргагчийн 2021 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор гарган, ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4 тайлангаар гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв.</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23,5 дахь хэсэгт заасны дагуу нийтийн албан томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилж байна. Тус газар 11 сарын байдлаар 3 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулсан.</p> <p>Авлигын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах гэрээг тус газрын 25 албан хаагчтай гэрээг байгуулав.</p> <p>Авлигатай тэмцэх газрын “Авлигатай тэмцэх газар” АТГ-ын Олон нийтийн төвийн “Авлигатай тэмцэх газар Олон нийтийн төв” Фэйсбүүк хуудсанд бүх албан хаагчдыг нэгдүүлэх, тус цахим хуудсанд нийтлэгдсэн мэдээ мэдээллийг Нийслэлийн нийгмийн даатгалын газар фэйсбүүк, пэйж хуудсаар түгээх сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллаа.</p>
--	--	--	--	--	--	--	---	--	--	---

3	4.1.2.2	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.		ННДГ		Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн Ухаалаг ажлын байр төслийг хэрэгжүүлж, нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд даатгуулагч болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй, чирэгдэлгүй нийгмийн үйлчилгээг авах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй, чирэгдэлгүй нийгмийн үйлчилгээг авах орчин байх.			<p>Нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн Ухаалаг ажлын байр төслийг хэрэгжүүлж, нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд даатгуулагч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд саад чирэгдэлгүй үйлчилгээ авах орчин бүрдүүлж хэлтсийн гадна байрлах тэргэнцэртэй иргэний налуу зам, явган хүний замыг тус тус засаж, шатны бариулыг шинэчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний стандарт бүхий орчныг бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Иргэд даатгуулагчид 2, 3 дугаар давхарт гарч, олон байцаагчтай уулзах, хүлээх шаардлагагүй болсноор нийгмийн даатгалын үйлчилгээг нэг цэгээс, түргэн шуурхай хүлээн авах ба хэлтсүүдэд угтах үйлчилгээний хэсэгт хөтөч байцаагч тогтмол ажиллаж, тосож үйлчлэхээс гадна иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн ойрын болон холын харааны шил, мөн сонсголын аппаратыг байршуулж, дуудлагын хонхны ажиллагааг тогтмол байлгаж тусламж шаардлагатай иргэдийн үйлчилгээ авах боломжоор ханган ажиллаж байна. Хөтөч байцаагч нь дохионы хэлний сургалтад хамрагдсан бөгөөд сонсголгүй иргэдэд үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж ажиллаж байна.</p>	
4	4.1.1.2	Төрийн мэдээлэл солилцсон “ХУР” системийг нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын		ННДГ		16628.7 мянга,	17000 мянга			2022 оны жилийн эцсийн байдлаар ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын залруулгыг холбогдох журмын дагуу албан бичиг хүсэлтийг үндэслэн мэдээллийн баазад залруулан ажилласан бөгөөд дээрх ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийг тухай бүр шинэчлэн төрийн үйлчилгээний нэгдсэн “ХУР” системд шинэчлэн оруулж иргэд, даатгуулагчдыг цахим мэдээлэл лавлагаа авах боломжийг бүрдүүлэн	

		хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ.								ажилласан.Төрийн мэдээлэл солилцсон “Хур” систем нь нийгмийн даатгалын хэлтсүүдийн хэрэглээнд нэвтэрсэн.Уг систем нь иргэд даатгуулагчид түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх, үнэн бодит мэдээллийг газар дээр нь хэвлэн тэтгэвэр тэтгэмж авах, сайн дурын даатгалын гэрээ хийхэд хэрэглэгдэж байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн “ХУР” системд 46 сервис тогтвортой ажиллаж, төрийн 18 байгууллага 46 сервис ашиглан 2022 оны 11 сарын 30-ны байдлаар 4,5 сая удаагийн хандалт хийж ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээллийг цахимаар авсан байна.
5	4.1.1.1	Нэг цонхны үйлчилгээний эрх зүйн орчин бүрдүүлнэ.		ННДГ		2021 онд “Нэг цэгийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийн төв”-өөр нийт 54,988 иргэн үйлчлүүлсэн байна.	2022 онд “Нэг цэгийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийн төв”-өөр нийт 60000 иргэн үйлчлүүлсэн байх.			2022 оны 04 дүгээр улирлын байдлаар Баянзүрх, Хан-Уул, Сонгино-Хайрхан, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Нэг цэгийн зөвлөгөө мэдээллийн төвөөр 217486 иргэд даатгуулагч үйлчилгээ авсан байна. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн нэг цонхны үйлчилгээгээр үзүүлж байгаа нийгмийн даатгалын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж Оршуулгын тэтгэмж, Ажилгүйдлийн тэтгэмжийг нэг цэгээр дамжуулан олгож байна.
6	4.2.3.1	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэргэжлийн болон үйлчилгээний ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах.		ННДГ		Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 256 сургалтад 4697 /давхардсан тоогоор/ албан	Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдад чиглэсэн 260 төлөвлөгөөт сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байх.			Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 296 сургалтад /давхардсан/ тоогоор 3972 /давхардсан тоогоор/ албан хаагчийг хамруулж ажилласан байна. Үүнээс: Дээд газраас болон дотооддоо зохион байгуулсан Нийгмийн даатгал болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар 109 удаагийн сургалтад 1203 албан хаагч, Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын талаар 31 удаагийн сургалтад 898, Хувь хүний хөгжлийн талаар /гэрчилгээ, сертификаттай сургалт/ 28 удаагийн сургалтад

							хаагчийг хамруулсан байна.				<p>471 албан хаагч, бусад 135 удаагийн сургалтад 1514 албан хаагчийг хамруулсан байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын систем” шинэчлэгдэн шинэ хувилбар нэвтэрч буйтай холбогдуулан цалингийн систем, Төрийн албан хаагчдын мэдээлэлийг шинэчлэх, баяжилтийг хийх цуврал цахим сургалтуудад сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, Хүний нөөц хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа, нар тухай бүр хамрагдлаа. Сургалтын үр дүнд: https://hrm.csc.gov.mn сайтад албан хаагчдын мэдээллийг бүрэн гүйцэт оруулж, мэдээллийн зөрүүтэй байдлыг арилган ТАЦН системд цалин татагдах нөхцөлийг бүрдүүлж мэдээллийн ямар нэгэн алдаагүй боллоо. 2. Байгууллагын нууц, Хувь хүний нууц, ХАСХОМ гаргах талаар НДЕГ-аас зохион байгуулсан сургалтад хэлтсийн дарга нар, Хүний нөөцийн мэргэжилтэн, хяналт шалгалтын байцаагч нар хамрагдлаа. 3. 2022.01.07-28 хооронд Төрийн албаны зөвлөлийн https://csc.gov.mn/b/70 вэб сайтын “Бодлогын иноваци_Вебинар” хэсэгт байршуулсан мэдлэг олгох цахим сургалтуудын файлыг байгууллагын дотоод сүлжээ, фэсбүүк хуудсаар түгээж албан хаагчдаар судлуулах ажлыг зохион байгуулж Тус газрын ёс зүйн зөвлөл хяналт тавьж ажиллаа. 4. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга: Тус газрын албан хаагчид дүүргүүдийн хүний нөөцийн мэргэжилтнүүдийг хамруулан цахимаар
--	--	--	--	--	--	--	----------------------------	--	--	--	---

										<p>зохион байгуулсан. Сургалтын чиглүүлэгч багшаар Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн сургагч багш Л.Ариунболд, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар ажиллаа.</p> <p>5. Ахисан түвшний Жендэрийн дүн шинжилгээ, цахим сургалтад Хяналт шалгалтын ахлах байцаагч Б.Батцэрэн, Архив бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл, И.Пүрэвжав нар хамрагдлаа.</p> <p>6. Тус газрын ёс зүйн зөвлөл, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав нар хамтран Төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлага сэдэвт танхимын сургалтад 19 албан хаагч хамрагдлаа. Сургалтаар Тамгын хэлтсийн дарга О.Байгалмаа, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай үндсэн ойлголт, ёс зүйн зөрчлийн талаарх ойлголтуудын талаар товч мэдээлэл өгч, Хүний нөөц хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Л.Гэрэлмаа 4 төрлийн бодит кэйс дээр тулгуурлан шийдвэрлэлтийн талаар анхаарах асуудлыг онцлон тайлбарлалаа.</p> <p>7. Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн 17 албан хаагч НДЕГ-аас зохион байгуулсан тэтгэвэр, тэтгэмж тогтооход анхаарах асуудал, цахим тэтгэмжийн талаарх сургалтад хамрагдаж Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаарх мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгалаа.</p> <p>8. “Алсын хараа 2050” Урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго зорилтуудыг танилцуулах богино хугацааны цахим болон танхимын сургалтад 2021 онд Санхүү</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

											<p>бүртгэлийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн ахлах нягтлан бодогч М.Цандмаа хамрагдаж гэрчилгээ авсан бол энэ онд Газрын дарга Г.Болорсүх, Тамгын хэлтсийн Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, Архив бичиг хэргийн ажилтан Б.Мөнхгэрэл, Санхүү бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч Б.Ариунтуяа нар хамрагдаж шалгалтаа өгч гэрчилгээ авсан.</p> <p>9. Нийслэлийн засаг даргын тамгын газрын дэргэдэх Хүний нөөцийн хөгжлийн төвөөс сар бүр зохион байгуулагддаг танхим болон цахим сургалтуудад идэвх санаачилгатай оролцож танхимаар ажлын байран дээрээ сургалт авах эрх үүссэний дагуу 2022 оны 09 дүгээр сарын 21-нд “Стресс менежмент” сэдэвт сургалтыг зохион байгуулж тус газрын 19 албан хаагч хамрагдлаа. Тус сургалтыг Сургалт хариуцсан мэргэжилтэн И.Пүрэвжав, сургагч багш Т.Оюундарь нар хөтлөн явуулж албан хаагчдад ажлын байран дээрх стрессийн шалтгаан үр дагаварын талаар тайлбарлаж, стрессээ удирдах ур чадвараа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхүйц олон сонирхолтой тест кэйс дээр ажиллуулж, google gmail цахим хаягийн хөтлөлт болон түүний боломжуудын талаар мэдээлэл зөвлөгөө өглөө.</p> <p>Удирдлагын академи, Удирдахуйн ухааны сургуулийн Төрийн удирдлагын магистрын зэрэг горилж Хяналт шалгалтын байцаагч Ц.Хандсүрэн, Санхүү бүртгэлийн хэлтсийн Сангийн тайлан бүртгэл хариуцсан мэргэжилтэн нягтлан бодогч Б.Ариунтуяа Мөн удирдахуйн ухааны сургуулийн Төрийн захиргааны менежмент магистрын гарагийн</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---

											сургалтад Хяналт шалгалтын ахлах байцаагч О.Ууганбаатар, хяналт шалгалтын байцаагч Ц.Оюунбилэг нар амжилттай суралцаж байна.	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР